

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.15 № 79
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд нийт хөрөнгө 1,670.0 сая төгрөгөөр өссөн ба үндсэн тоноглолд хийсэн урсгал болон их засварын ажлуудын гүйцэтгэлийг санхүүгийн тайланд тусгаж, тодруулж толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр барьсан хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх 126,286.5 сая төгрөгийн өргөтгөлийн ажил дуусаж, улсын комисс хүлээн авч, ашиглаж эхэлсэн боловч хөрөнгийг бүртгэх, зээлийн төлөлтийн талаарх эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 80,604.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 80,871.1 сая төгрөгөөр, 288.1 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 8,340.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 84,880.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 81,383.0 сая төгрөгийн зардал гарган, 3,475.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 64 ажилд өөрийн эх үүсвэрээс 7,229.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, 92.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	75,553,004.77	523,280,011.30
1.1.2	Дансны авлага	3,409,265,747.37	3,923,726,572.30
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	190,735,139.18	444,512,801.78
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	3,360,728,133.81	4,525,815,010.95
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,702,649,033.98	1,096,122,158.53
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,738,931,059.11	10,513,456,554.86
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	67,292,432,000.82	67,242,241,125.89
1.2.2	Биет бус хөрөнгө	21,125,404,933.43	21,071,534,516.60
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	88,417,836,934.25	88,313,775,642.49
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	97,156,767,993.36	98,827,232,197.35
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	9,355,467,419.71	3,628,928,183.21
2.1.1.2	Цалингийн өглөг	33,356,877.85	2,523,857,334.31
2.1.1.3	Татварын өр	500,064,657.98	573,760,864.87
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	108,495,906.24	48,456,956.35
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	1,600,000,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,266,885,154.61	1,211,356,712.69
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,264,270,016.39	9,586,360,051.43
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	2,000,000,000.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,397,443,924.72	741,907,519.22

2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,397,443,924.72	2,741,907,519.22
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,661,713,941.11	12,328,267,570.65
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	20,937,713,000.00	20,937,713,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(16,025,166,638.65)	(13,021,256,064.20)
2.3.11	Эздийн өмчийн дүн	83,495,054,052.25	86,498,964,626.70
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	97,156,767,993.36	98,827,232,197.35

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	61,343,644,109.51	83,351,247,360.11
2	Борлуулалтын өртөг	60,512,421,055.00	72,560,402,640.13
3	Нийт ашиг (алдагдал)	831,223,054.51	10,790,844,719.98
4	Түрээсийн орлого	36,591,051.00	36,657,360.00
5	Хүүгийн орлого	0.00	5,727,669.89
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	1,480,019,954.67	1,486,338,112.05
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,058,537,879.83	5,628,241,009.63
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,416,191,327.27	1,592,582,447.63
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	205,088,963.13	1,584,570,064.36
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(17,154,593.45)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(3,331,984,110.05)	3,497,019,746.85
19	Орлогын татварын зардал	329,641,996.67	493,109,172.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(3,661,626,106.72)	3,003,910,574.45
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(3,661,626,106.72)	3,003,910,574.45
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(3,661,626,106.72)	3,003,910,574.45
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,336,490,531.93)	87,183,730,158.97
2	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,336,490,531.93)	87,183,730,158.97
3	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(27,050,000.00)	(27,050,000.00)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(3,661,626,106.72)	(3,661,626,106.72)
5	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(16,025,166,638.65)	83,495,054,052.25
6	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(16,025,166,638.65)	83,495,054,052.25
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	3,003,910,574.45	3,003,910,574.45
8	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(13,021,256,064.20)	86,498,964,626.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	59,646,396,029.20	75,060,865,063.17
1.1.1.	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	59,536,960,121.76	75,005,021,549.17
1.1.6.	Бусад мөнгөн орлого	109,435,907.44	55,843,514.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(54,989,695,316.10)	(67,962,886,114.57)
1.2.1.	Ажиллагчдад төлсөн	(10,849,720,805.00)	(11,668,986,709.60)
1.2.2.	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(3,666,983,347.27)	(4,267,500,000.00)
1.2.3.	Бараа материал худалдан авахад төлсөн	(18,658,619,128.19)	(40,717,804,668.95)
1.2.4.	Ашиглалтын зардалд төлсөн	(2,275,147,212.00)	(168,915,474.00)
1.2.5.	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(17,055,212,141.23)	(6,046,450,864.87)
1.2.6.	Хүүгийн төлбөрт төлсөн		(41,187,945.21)
1.2.7.	Татварын байгууллагад төлсөн	(2,308,324,159.01)	(3,816,294,598.79)
1.2.8.	Даатгалын төлбөрт төлсөн	(8,442,622.61)	(11,991,239.04)
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	(167,245,900.79)	(1,223,754,614.11)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,656,700,713.10	7,097,978,948.60
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	5,976,669.89
2.1.6.	Хүлээн авсан хүүгийн орлого		5,976,669.89
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(4,890,697,214.68)	(10,256,228,611.99)
2.2.1.	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(4,822,754,772.01)	(10,256,228,611.99)
2.2.2.	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(67,942,442.67)	

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,890,697,214.68)	(10,250,251,942.10)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	3,600,000,000.00
3.1.1.	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		3,600,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.3.	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
3.2.4.	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	3,600,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(233,996,501.58)	447,727,006.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	309,549,506.35	75,553,004.77
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,553,004.77	523,280,011.27

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Үйлдвэрлэсэн: ЦЭХ		сая.квтц	427.1	425.5	440.0	14.5	101.9
	Үйлдвэрлэсэн: ДЭХ		мян.Гкал	692.7	692.9	696.6	3.7	
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим	Хувиар	хувь	13.59	13.73	13.29	(0.45)	
		Биетээр	сая.квтц	58.1	58.4	58.5	0.0	
	Түгээсэн: ЦЭХ		сая.квтц	369.1	367.1	381.6	14.5	
	Түгээсэн: ДЭХ		мян.Гкал	641.5	643.5	643.6	0.0	
2	Нийт орлого		сая.төг	62,860.2	80,604.5	84,880.0	4,275.5	105.3
	Үүнээс:	Цэвэр борлуулалт	сая.төг	61,343.6	79,137.0	83,351.2	4,214.3	
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,516.6	1,467.5	1,528.7	61.2	
3	Нийт зардал		сая.төг	66,192.3	80,871.1	81,383.0	511.8	99.4
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	65,987.2	79,131.0	79,781.2	650.2	
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	205.1	1,741.1	1,601.7	(138.4)	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	(3,332.3)	(266.7)	3,497.0	3,763.7	120.0
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	(3,661.6)	(288.1)	3,475.5	3,763.7	120.0
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.05	1.00	0.96	(0.04)	104.6
7	Нийт авлага		сая.төг	3,600.0	2,700.0	4,368.2	1,668.2	61.8
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	2,671.7	2,690.0	3,517.9	827.9	
		бусад	сая.төг	928.3	10.0	850.3	840.3	
8	Нийт өглөг		сая.төг	13,661.7	13,081.7	12,328.3	(753.4)	106.1
	Үүнээс:	БХӨТ	сая.төг	12,264.3	10,368.8	9,586.4	(782.4)	
		УХӨТ	сая.төг	1,397.4	2,712.9	2,741.9	29.0	
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	461	465	465	0	100.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	13,510.0	15,696.3	17,808.2	2,111.9	88.1

11	Жишмэл тулшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	415.4	423.6	411.7	(11.9)	101.6
		ДЭХ	кг/Гкал	187.6	190.7	190.3	(0.4)	
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		сая.төг	10,182.5	8,340.9	7,294.3	(1,046.6)	92.2

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 235.2 сая төгрөгийн төрлийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 235.2 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Албан ажлын зайлшгүй шаардлагаар автомашин ашиглах ажил, үйлчилгээний жагсаалт, хэрэглээний хязгаарыг тогтоогоогүйгээр 10.6 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь НББОУС 1, НББОУС 2 болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул бараа материалын тайлан, анхан шатны баримтад,
- Тайлант онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 18 ажилтанд өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжийг хүчин төгөлдөр мөрдөж буй хамтын гэрээнд зааснаар олгоогүй, хамтын хэлэлцээрт нийцүүлж 224.6 сая төгрөг олгосон нь НББОУС 1, НББОУС 19 болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул тэтгэмж олгох хамтын гэрээ, анхан шатны баримтад,
- Ажлын байрны тодорхойлолтод тусгасан шалгуурыг ажлын байр зарласан шалгууртай нийцүүлээгүй, зарласан шалгуурыг хангаагүй ажилтан томилсонд хяналт хэрэгжүүлээгүй нь Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрэм болон аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүйг үйл ажиллагааны тайлан, анхан шатны баримтад тус тус залруулав.

Аудитаар нийт 1,248.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 25.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 28.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1,194.7 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар залруулаагүй 13 зөрчилтэй асуудал нь 1,248.6 сая төгрөгийн материаллаг зөрчил бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөөгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож, 2.4 сая төгрөгийн зардал илүү зарцуулсан, 2024-2025 оны хамтын гэрээ байгуулах ажлын хэсгийн 13 ажилтанд 49 цаг илүү ажилласны хөлсөнд 1.6 сая төгрөг олгосон, томилолтоор ажилласан хугацааны хоолны мөнгийг давхардуулан бодож 1.8 сая төгрөг илүү олгосон, эрх бүхий байгууллагын шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүйгээр 2023 оны хагас болон жилийн эцсийн тооллого хийсэн 95 ажилтанд 11.6 сая төгрөгийн урамшуулал олгосон, өмнөх оны зөрчлийг давтан бүтээмж, хэмнэлтийн урамшуулалд 8.2 сая төгрөг олгохоор тооцож, шийдвэр гаргуулсан зэрэгт 5 төлбөрийн акт акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтээс 28.3 сая төгрөгийг ТУЗ-аар шийдвэрлүүлэн 5 төсөл, арга хэмжээнд зарцуулсанд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6 дах хэсэг 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасантай нийцэхгүй, аудитын ангилал, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 1: Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн санд батлагдаагүй, тухайн зардлыг ТУЗ-өөр батлаагүй байтал ҮЭХ-ны даргад удаан жил, сарын болон жилийн үр дүнгийн урамшууллыг хамтын хэлэлцээр, гэрээг үндэслэн 29.6 сая төгрөг олгосон байна. Энэ нь Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрмийн 8.11.8-д “Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, нэмэлт гэрээ, хамтын гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх”, 8.11.4-т “Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасантай нийцэхгүй аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 2: ҮЭХ-ны даргын удаан жилийн нэмэгдэл, урамшууллын зардлыг ТУЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, мөрдөн ажиллах.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны цалингийн зардалд өмнөх оны жилийн урамшууллыг баталж, тухайн жилийн үйл ажиллагааны зардалд бүртгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар

хөтөлнө”, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрмийн 8.11.4-т “Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах” гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 3: Байгууллагын төлөвлөлт, зарцуулалтыг нийцүүлж аккрузл сууриар үнэн зөв бүртгэх.

4. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 170 талбарын мэдээллээс 1 мэдээллийн хугацааг хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 560.9 сая төгрөгийн орлогын 3 мөнгөн гүйлгээ, 13 тушаалыг мэдээлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”; 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”; 7 дугаар зүйлийн 7.1-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 4: Байгууллагын шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд, үнэн зөв мэдээлж, хариуцлагыг сайжруулах.

5. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлоогүйгээс дотоод хяналтын хэлтэс үр нөлөөгүй ажилласан болон зарим хэлтэс, албаны чиг үүрэг давхардаж байгаад дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрмийн 8.11.8-д “Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, нэмэлт гэрээ, хамтын гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх”, 8.11.4-т “Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах” гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 5: Баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тогтоож, чиг үүргийн давхардлыг арилган, цех, хэлтэс, албадын үр нөлөөг сайжруулах.

6. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Материалын нөөцийг 1,165.0 сая төгрөгөөр өсгөсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 6: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор заавал байлгах нөөцийг улирлын онцлогоос хамааруулан тогтоон мөрдөж, үр ашиггүй, шаардлагагүй бараа материал бэлтгэхгүй байх.

7. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байршуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.3-т "Энэ хуулийн 15.4-т заасан гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна", 20.4-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна" гэж заасантай нийцээгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 7: Нийтийн ил тод мэдээллийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсаар ил тод, нээлттэй байршуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөг/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭДЦС ТӨХК	3	235.2	1		2	235.2	3	235.2				
Дүн	3	235.2	1		2	235.2	3	235.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөг/			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
ЭДЦС ТӨХК	8	55.2	5	25.6			3	29.6				
Дүн	8	55.2	5	25.6			3	29.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил	/сая төгрөг/		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЭДЦС ТӨХК	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЭДЦС ТӨХК	4	1,193.4			1	28.3	3	1,165.1
Дүн	4	1,193.4			1	28.3	3	1,165.1
Нийт дүн	5	1,193.4			1	28.3	4	1,165.1

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨА	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			